

ТӨВ АЙМГИЙН 2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2023 оны 4 сарын 03-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2023 оны 03 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ, Ажлын албанаас 2023 оны 03 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус -4 дүгээр хуралдаан 03-р сарын 30-ны өдрийн “Пүрэв” гарагт хуралдаж нийт 7 асуудал хэлэлцэж, 8 тогтоол батлан гаргалаа.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус -4 дүгээр Хуралдаанаар:

Аймгийн ИТХ-ын ээлжит бус 4 дүгээр Хуралдаан 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдөр 85.3 хувийн ирцтэйгээр хуралдав. Үүнд:

1. Аймгийн хэмжээнд 2023 онд ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтдын тоо хуваарь батлах тухай өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын газрын харилцаа, байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн нутаг дэвсгэрээс 2023 онд ахуйн зориулалтаар агнах, агнуурын амьтдын тоо хуваарийг хэлэлцэн батлав.

2. “Олон хүүхэд төрүүлж өсгөн “Алдарт эх” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнуулах хүсэлт уламжлах тухай” асуудлыг хэлэлцээд “Алдарт эх” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах болзол хангасан “Алдарт эх” нэгдүгээр одонгоор 33, “Алдарт эх” хоёрдугаар одонгоор 271, аймгийн 27 сумдын 304 эхчүүдийг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжлав.

3. Хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтөд захиргааны актыг нийцүүлэх зорилгоор аймгийн ИТХ-ын шийдвэрт Ажлын албанаас хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн эрх зүйн актын хүрээнд цаашид авах арга хэмжээний тухай мэдээлэл, түүнд Хурлын Нутгийн удирдлага, цахим хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн 2004 оноос хойш баталсан зарим тогтоолууд нь хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт, зохицуулалтын давхардал, хэрэгжүүлэх, хугацаа дуусгавар болсон тул хүчингүй болсонд тооцож, жагсаалтыг тогтоолын хавсралтаар батлав.

4. Аймгийн Засаг даргын өргөн мэдүүлсэн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгийг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах журам батлах тухай өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо, Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлт, төлөөлөгчдөөс гарсан саналыг хэлэлцээд тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгийг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах журмыг 1 дүгээр, Байгаль орчныг хамгаалах уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, хандив, тусламж авах асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай байгуулах гэрээний загварыг 2 дугаар хавсралтаар батлав.

5. Аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших тухай “Маргад тражу” ХХК-ний хүсэлтэд санал авах тухай асуудал, Ашигт малтмал газрын тосны газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дүгнэлт, Баянцогт сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 61 дүгээр тогтоол, түүнд Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших тухай хүсэлтийг хуралдаанд оролцсон Төлөөлөгчдийн олонхийн саналаар дэмжих боломжтой гэж үзэв.

Мөн аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших тухай “Хан чулуу од плант” ХХК-ний хүсэлтэд санал авах тухай асуудал, Ашигт малтмал газрын тосны газар, аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн дүгнэлт, Эрдэнэ сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 55 дугаар тогтоол, түүнд Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших тухай хүсэлтийг хуралдаанд оролцсон

Төлөөлөгчдийн олонхийн саналаар дэмжих боломжтой гэж үзэн “Санал өгөх тухай” тогтоолуудыг тус тус батлав.

6.Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны 10/1057 тоот албан бичгээр ирүүлсэн Төв аймгийн 25 сумын 206 байршилд хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжтой 116715.54 гектар талбайг ялган санал ирүүлэх мэдэгдлийн талаар аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатарын өргөн мэдүүлсэн танилцуулга, Төв аймгийн 25 сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ирүүлсэн санал, түүнд Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн 100 хувийн саналаар дэмжих боломжгүй гэж үзэн “Санал өгөх тухай” тогтоолыг баталж, тогтоолыг холбогдох баримт материалын хамт Ашигт малтмал, газрын тосны газарт уламжлахыг аймгийн Засаг даргад даалгав.

7.“Нөхөн Сонгууль зохион байгуулах аймгийн Сонгуулийн хороо байгуулах тухай” асуудлыг хэлэлцээд Төв аймгийн Бүрэн, Өндөрширээт, Заамар сумдад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан сумдын сонгуулийн хороог мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах “Аймгийн сонгуулийн хороо”-г 7 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа.

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн Хуралдаан:

Аймгийн ИТХ-ын Зөвлөлийн 02 дугаар хуралдаан 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдөр хуралдаж 7 асуудал хэлэлцсэнээс:

1.Аймгийн ИТХ-н зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг Хурлын даргын захирамжаар батлав.

2.Ахуйн зориулалтаар агнах, барих, ан амьтдын хуваарь батлах тухай асуудлыг хэлэлцэн Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүллээ.

3“Алдарт эх”-ийн одонгоор шагнуулах хүсэлт уламжлах тухай

4.Аймгийн ИТХ-аас баталсан зарим тогтоолуудыг хүчингүй болгох тухай

5.Аймгийн Сонгуулийн хороо байгуулах тухай асуудлуудыг хэлэлцэн Хурлын Нутгийн удирдлага, Цахим хөгжлийн хороонд шилжүүллээ.

6.Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгийг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах журам батлах тухай асуудлуудыг Хурлын Төсөв санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо, Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороодод шилжүүллээ.

7.Хуралдааны тов тогтоож, хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай асуудлыг хэлэлцээд аймгийн ИТХ-ын ээлжит 14-р хуралдааныг 2022 оны 03 сарын 30-ны өдөр хуралдахаар тов тогтоосон.

Аймгийн ИТХ-ын хуралдаанаар нэмэл өөрчлөлт орох болсонтой холбогдуулан аймгийн ИТХ-ын ээлжит бус -3 дугаар Хуралдаан 2023 оны 03-р сарын 23-ны өдрийн “Пүрэв” гарагт аймгийн ЗДТГ-ын “Соёмбо” танхимд хуралдлаа.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус-3 дугаар Хуралдаанаар:

1.Аймгийн Засаг даргын 2023 оны 03-р сарын 20-ны өдрийн 01/468 тоот албан бичгээр уламжилсан түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн шинээр авах хүсэлтийн тухай болон 2023 оны 22-ны өдрийн 01/507 тоот албан бичгээр уламжилсан сонгон шалгаруулалтаар олгох талбайн солбилцолд санал авах тухай асуудлуудыг хэлэлцээд Хурлын Газрын харилцаа, байгаль орчин хөдөөгийн хөгжлийн хороонд шилжүүлэв.

2.Тус 2 асуудлыг аймгийн ИТХ-ын ээлжит бус-4 дүгээр хуралдаанаар хэлэлцэхээр “Хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулах тухай” захирамжийн төслийг батлав.

Аймгийн ИТХ-ын Ажлын албаны хүрээнд:

3 дугаар сард аймгийн ИТХ-ын дарга, Ажлын албанд хандсан 20 албан бичиг ирснийг бүртгэн авч хариу хүргүүлэх шаардлагатай 4 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна. Аймгийн ИТХ-д хандан иргэдээс 6 өргөдөл ирснээс 3 өргөдлийн хариуг хүргүүлсэн.

Аймгийн ИТХ-ын дарга, Хурлын Ажлын албанаас УИХ-ын гишүүд, Ерөнхийлөгчийн тамгын газар, салбарын яамдад болон холбогдох албан байгууллагад 22 бичиг гарган хүргүүллээ.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийг чадавхжуулах, туршлага солилцуулахаар Бүгд Найрамдах Солонгос Улсын Бие даасан Чэжү хот, Кёнги мужийн Пёнгтек хотод 2023 оны 03 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан хоёр талт уулзалт зөвлөгөөнд Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон Ажлын албаны төлөөлөл оролцов.

БНСУ-ын бие даасан Чэжү хотын ИТХ-тай 2017 онд байгуулсан гадаад харилцаа хамтын ажиллагааны “Санамж бичиг”- ийн хүрээнд тус хотын ИТХ-ын дарга Ким Кён Хакын урилгаар

аймгийн ИТХ-ын 8 төлөөлөгч тус мужид албан айлчлал хийж, Чөжү хотын ИТХ-ын үйл ажиллагаа болон Шинжлэх ухаан технологийн төв, “Халим” цэцэрлэгт хүрээлэнтэй танилцаж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

Мөн БНСУ-ын Пёнгтек хотын захирагч Жон Жонсаны урилгаар аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар тэргүүтэй аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 19 төлөөлөгч тус хотод зочлон хотын ИТХ-ын дарга Ёоо Сеүнг Ян болон, хотын захирагч Жон Жонсан нартай албан уулзалт хийж, далайн боомт, хөдөө аж ахуйн хөгжлийн төв, “Байдари” номын сангийн үйл ажиллагаа, “Самсунг” электроникс үйлдвэрийн хагас дамжуулагчийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцан, БНСУ-ын хөгжил дэвшил, техник технологийн хөгжил, арга барилаас мэдээлэл туршлага солилцлоо.

Бусад ажлын хүрээнд:

Төв аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр сумдын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах 5 сумдын бүсчилсэн сургалтыг Алтанбулаг суманд зохион байгуулж, Алтанбулаг, Баян-өнжүүл, Баянцагаан, Бүрэн, Дэлгэрхаан 5 сумдын нийт 43 албан хаагч хамрагдлаа.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд мөрдөгч хүүхдүүд зөвлөж байна цувралын мэдээллийн эхний хэсгийг нийтэд мэдээлж ажилласнаас гадан өвөлжилт хүндэрсэн малчин өрхөд яаралтай тусламж үзүүлэх төслийн уулзалтад Ажлын албаны ахлах мэргэжилтэнүүд хамрагдлаа.

Иргэдийн аюулгүй, ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн гаралтыг бууруулах зорилгоор өнгөрсөн оны 10 дугаар сард Чингэлтэй дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар камерын нэгдсэн төвийг байгуулжээ. Уг төвийн үйл ажиллагааг нийслэл хотод жишиг болгон, үйл ажиллагаа болон гэмт хэрэг зөрчлийг хэрхэн илрүүлж байгаа сайн жишгийг судлахаар өнөөдөр Төв аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, аймгийн Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан чиглэлийн ахлах мэргэжилтэн Н.Нарантуяа, Дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, Цагдаагийн хошууч Г.Жанчив нар “Камерын хяналтын нэгдсэн төв”-д ажиллаж, үйл ажиллагааны талаар мэдээллийг сонслоо. Туршлага судлах ажлын хүрээнд Төв аймгийн Зуунмод хотыг бүрэн камержуулахад шаардагдах тоног төхөөрөмжийн үзүүлэлт, чанар, төсөв хөрөнгийн талаар судалж танилцлаа.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссын ажлын хүрээнд:

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын төлөвлөгөөг 2 бүлэг, 4 зорилт, 18 арга хэмжээтэйгээр батлан хэрэгжүүлж байна. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисстой хамтран, 2020, 2021 оны шүүхийн шийдвэртэй материалуудыг тулган, Төв аймгийн хэмжээнд Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн нөхөх олговор авсан иргэдийг баталгаажуулав.

Төв аймгийн ЦАУЗБСК-т бүртгэлгүй байсан 2021 оны шүүхийн шийдвэртэй хэлмэгдэгч Б.Балжирын нэхэмжлэгч Ц.Диваахүү, 2022 оны шүүхийн шийдвэртэй хэлмэгдэгч Н.Тувааны нэхэмжлэгч Ц.Отгонжаргал, С.Нармандах, 2023 оны шүүхийн шийдвэртэй хэлмэгдэгч С.Лувсандагвын нэхэмжлэгч Ш.Даваасүрэн, Л.Бадарч нарыг бүртгэлд шинээр авлаа.

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар хэлмэгдэгч Ж.Чүлтэм, Д.Гүрсэд, Д.Дорлиг, И.Цэвээнжав, Ц.Жамбалдорж, Ж.Лувсанчимэд нарын шүүхийн шийдвэрээр тогтоосон нэхэмжлэгч үр хүүхдүүдэд нь 640.0 сая төгрөгийн нөхөх олговор олголоо.

Хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд Аргалант, Батсүмбэр, Баянжаргалан, Баянчандмань, Бүрэн, Дэлгэрхаан, Жаргалант, Заамар, Зуунмод, Мөнгөнморьт, Сэргэлэн, Эрдэнэ, Эрдэнэсант сумдаас хэлмэгдэгчдийн талаарх мэдээллийг авч Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын нэгдсэн мэдээлэлд оруулахаар хүргүүлээд байна.

ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлыг 3 дугаар сард 1 удаа зохион байгуулж, 6 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 03 дугаар сарын 13, 27-ны өдрүүдэд танхимаар зохион байгууллаа.

“Иргэдтэй уулзах цаг” арга хэмжээг 2023 онд зохион байгуулах хуваарийн дагуу 03 сарын 01-ний өдөр аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд зохион байгуулж, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга С.Магнайбаяр оролцов.

Аймаг, сумын хэмжээнд төрийн одон медальд тодорхойлогдсон 61 иргэний тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Ерөнхийлөгчийн тамгын газарт уламжлав.

Хотоос хөдөө рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөний талаар болон шилжин суурьшигдын талаар цогц ойлголт өгөх 1 өдрийн сургалтыг аймагт шилжилт хөдөлгөөний бодлогыг тодорхойлогч нар болон орон нутагт шилжин суурьшигчдад үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий төрийн албан хаагчдыг оролцоуулсан 2 удаагийн 110 хүний сургалтыг ЗГХЭГ, Удирдлагын академи, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран 2023.03.07-ны өдөр аймгийн төвд зохион байгуулав.

Засгийн газраас зохион байгуулах “Хөдөөгийн сэргэлт” үндэсний чуулган”-д аймгийн салбарын төлөөлөл 15 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид 2023.03.10-ны өдөр оролцов. Мөн чуулганы үеэр “Нээлттэй Төв аймаг” мэдээллийн Түц бэлтгэн ажиллуулж сонирхсон иргэдийг мэдээллээр хангав.

Монгол Улсын Засгийн газраас батлан хэрэгжүүлж буй “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүний эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ын уялдаа холбоо, зорилго зорилтыг төрийн албан хаагчдад сурталчлан таниулах, хэрэгжүүлэх, үр дүнг нь үнэлэх сертификатын сургалтыг Ерөнхий сайдын ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Удирдлагын академи Төв аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран 2023 оны 03-р сарын 21-29-ны өдрүүдэд зохион байгуулж, аймаг сумдын 300 төрийн албан хаагчийг хамруулан 2 өдрөөр нийт 3 удаа зохион байгуулав. Сургалтанд хамрагдсан 300 сургагч багш нар сум байгууллагадаа Алсын хараа-2050 сургалтын агуулгаар хагас өдрийн сургалтыг нийт 1200 төрийн албан хаагч, иргэнд зохион байгуулав.

Засгийн газрын Хот хөдөөгийн сэргэлт бодлогын хүрээнд “НЭЭЛТЭЙ АЙМАГ” цахим мэдээллийн хуудсыг шилжин суурьшигч иргэд, аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай мэдээлэл хүргэх зорилгоор нээж байгаа бөгөөд аймаг бүр 5 бүлэг судалгааг мэдээллийн санд оруулав.

ЗГХЭГ-аас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2023 оныг Авлигатай тэмцэх жил болгосонтой холбогдуулан зохион байгуулж байгаа “Шүүр” ажиллагааг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу 3 ажлын хэсэг томилон 27 сумд, төрийн байгууллагуудад тусгай удирдамжаар шалгалт хийв.

“Цаг үеийн ажлыг эрчимжүүлэх тухай” аймгийн Засаг даргын 2023.03.29-ний өдрийн №03 дугаар албан даалгаврыг батлуулж сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

ERP төрийн байгууллагуудын цахим системийн ашиглалтын талаарх сургалтыг 27 сумдын төрийн байгууллагуудын холбогдох албан утшаалтнуудад цахим хэлбэрээр, аймгийн төвийн төрийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудад танхимаар Аймгийн ЗДТГ, агентлагаас-46, сумаас 36 албан хаагчдад Цахим хөгжлийн яамтай хамтран 1 өдрийн сургалт зохион байгуулав.

Зуунмод сумын Хэсгийн ахлагчдын зөвлөгөөнд нийт 25 хүнд “Төрийн байгууллага дахь мэдээлэл ба хүний эрх” сэдвээр мэдээлэл зөвлөмж өгч, төрийн албан хаагчийн ёс зүйн талаар сургалт хийв.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:

2023 оны 03 дугаар сард аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт 16 байгууллага 600 төрлийн үйлчилгээг 7381 иргэнд, өдөрт дунджаар 300-350 иргэнд хүргэн үйлчилжээ.

Цахим үйлчилгээний нэгдсэн систем /www.e-mongolia.mn/-ээр дамжуулан аймгийн хэмжээнд 1607 лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас 716 лавлагаа үйлчилгээ авсан байна. Мөн E-Mongolia үйлчилгээний тухай заавар зөвлөмж, төрийн үйлчилгээг цахимаар авах боломжийн тухай мэдээ мэдээллийг 103 иргэнд хүргэж ажилласан байна.

Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд 6 гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжилсан.

Өөрөө өөртөө үйлчлэх цахим мэдээллийн буланд иргэд өөртөө үйлчлэх зориулалт бүхий газрын албаны киоск машин, төлбөр төлөлтийн “Гэрэгэ” киоск машинуудыг байршуулсан. Мөн Цахим үйлчилгээний нэгдсэн систем www.e-mongolia.mn, Газрын мэдээллийн нэгдсэн сангийн www.egazar.gov.mn, Аймгийн албан ёсны веб сайт www.tov.gov.mn, Аймгийн статистикийн

хэлтсийн www.nso.gov.mn сайтуудыг холбосон 4 ухаалаг дэлгэцийг тус тус байршуулан иргэдэд цаг үеийн болон дотоод ажил үйлчилгээтэй холбоотой мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох www.egazar.gov.mn сайтаар дамжуулан нийт 102 иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан 27 иргэн машины татвар, торгууль, улсын бүртгэлийн лавлагаа, жолоочийн хариуцлагын даатгал, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээнүүдийг авсан.

Мөн үйлчилгээний нэгдсэн төвд аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нээлттэй өдөрлөг болж иргэдэд иргэний бүртгэл болон үл хөдлөхийн бүртгэл лавлагаар газар дээр нь үйлчилгээ үзүүлэв.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Улсын онцгой комиссын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар “ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай”-ын хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 22-ны 02 дугаар албан даалгавар батлуулж сумд, байгууллагуудад хүргүүлэн ажиллав.

Жаргалант суманд зохион байгуулах гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн удирдамжийг аймгийн Онцгой комиссын орлогч даргаар батлуулан сумдад хүргүүлэв.

Аймгийн Онцгой комиссын орлогч дарга мал, амьтны гоц халдварт өвчин гарсан Баян, Баянцогт сумдад ажиллах удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллав.

Японы хүүхдийг ивээх сангаас Борнуур, Эрдэнэ, Эрдэнэсант сумдын өвөлжилт хүндэрсэн иргэдэд тусламж үзүүлсэн төслийн хаалтын хэлэлцүүлэгт аймгийн Онцгой комиссын 2022-2023 оны өвөлжилтийн нөхцөл байдалд хариу арга хэмжээ авсан ажлын тайланг танилцуулж, оролцсон.

Нийслэлийн Налайх, Багануур, Багахангай, Сонгино хайрхан, Хан-Уул дүүрэг, Дундговь, Сэлэнгэ, Хэнтий аймагтай хамтран ажиллах төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна.

Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газарт Онцгой байдлын газрын даргын баталсан төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг удирдамжийн хүрээнд 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсан.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Шар усны үерээс урьдчилан сэргийлэх тухай” нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хүрээнд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 03/01 дүгээр албан мэдэгдэл гаргаж сумдад хүргүүлсэн. Мөн Зуунмод сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/80 дугаар захирамжаар ажлын хэсэг томилон 6 багийн нутаг дэвсгэрт байрлах үерийн далан, шуудуунд үзлэг, шалгалт хийж ажилласан болно.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Төр захиргааны байгууллагын барилга байгууламжид гамшгаас хамгаалах, галын аюулаас урьдчилан сэргийлэх болон гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулах удирдамж”-ийн хүрээнд Онцгой байдлын газрын даргаар төлөвлөгөөт хяналт, шалгалтын удирдамж батлуулан Аймгийн Засаг даргын Тамгын газар, нутгийн удирдлагын II дугаар байр, Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар, 6 багийн төвийн хамруулан зохион байгуулав.

Аюулт үзэгдэл, ослын төрөл тус бүрт урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай алба хаагчдыг бэлтгэх зорилгоор ангиллын сургалт зохион байгуулах удирдамж гарган батлуулж, Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгийн алба хаагчид, мэргэжилтэн нартаа хамтран ангиллын сургалтыг танхим хэлбэрээр зохион байгуулж 7 удаагийн 14 цагийн сургалтаар 676 хүнийг хамрууллаа.

Олон улсын иргэний хамгаалалтын өдрийг тохиолдуулан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, Онцгой байдлын үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор “Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв”-тэй танилцуулах арга хэмжээг аймгийн Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн 6 бүлгийн 192 хүүхдийг хүүхэд, багачуудыг хамруулан зохион байгуулав.

2023 онд Олон улсын иргэний хамгаалалтын байгууллагаас “Ирээдүй хойч үеийнхээ аюулгүй байдлын төлөө дэлхийн тэргүүлэх салбарын мэргэжилтнүүдийг нэгтгэе” уриан дор олон улсын иргэний хамгаалалтын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх болсонтой холбогдуулан Баянчандмань, Батсүмбэр, Борнуур, Сүмбэр сумдын төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд ангийн сурагчид, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хүүхэд, багачуудад гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх танхимын сургалтыг зохион байгуулав.

Тус сургалтаар Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн дагуу газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах тухай хууль, галын аюулгүй байдлын тухай хууль сэдвүүдээр нийт 22 удаагийн сургалт зохион байгуулж, 2517 хүнийг хамруулсан байна.

“Олон Улсын иргэний хамгаалалтын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх аян”-ы удирдамжийн хүрээнд Онцгой байдлын албаны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, зорилгоор Зуунмод сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Гамшгийн эрсдэлийг бууруулахад-Хүүхэд бидний оролцоо” сэдэвт эссэ бичлэгийн уралдаан зарлалаа.

Зуунмод сум дахь Гал түймэр унтраах, аврах 24 дүгээр анги, Эрэн хайх, аврах салбарын алба хаагчидтай хамтран “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгууллаа. Тус өдөрлөгийн хүрээнд Онцгой байдлын байгууллагын техник, багаж хэрэгсэл, үйл ажиллагааг сурталчилснаас гадна, иргэдэд болзошгүй гамшиг ослоос урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжийг өгч, холбогдох хууль тогтоомжийг сурталчлан ажиллалаа. Өдөрлөгт Зуунмод сум дахь ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 12 бүлгийн 512 хүүхдийг хамрууллаа.

Тус өдрийг тохиолдуулан Онцгой байдлын газрын даргаар алба хаагчдын дунд “Марш тактик” тусгай бэлтгэлийн аварга шалгаруулах 2 үе шаттай тэмцээн зохион байгуулав. Тус арга хэмжээнд Зуунмод суманд үүрэг гүйцэтгэж байгаа Гал түймэр унтраах аврах 24-р анги, Эрэн хайх, аврах салбар, Зуунмод сум дахь 07-р ангийн нийт 60 гаруй алба хаагчид 5 баг болон оролцож аваргуудаа шалгарууллаа.

“Дэлхийн иргэний хамгаалалтын өдөр”-ийг тохиолдуулан бэлтгэсэн мэдээ мэдээллийг байгууллагын www.tuv.nema.gov.mn веб сайт, орон нутгийн TBS телевизээр 2 төрлийн хичээлийг өдөрт 2 удаагийн давтамжтайгаар 10 удаа нэвтрүүлж, Төв Онцгой байдлын газар пэйж хуудсанд байршуулан аймгийн 27 сумын хэмжээнд олон нийтэд түгээн ажиллалаа.

Орон нутгийн TBS телевизээр цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үед хол замд зорчихгүй байх, бэлтгэл бэлэн байдлаа сайтар хангах, дулаан хувцаслах, баталгаат зам гүүр, маршрутаар явах, Онцгой байдлын байгууллагаас өгч буй заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цаг тухай бүр телевизээр дамжуулан ард иргэдэд өдрийн 4 удаагийн давтамжтайгаар нийт 72 удаа хүргэн ажилласан.

Бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь цоожлон үлдээхгүй байх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж гэр, орон сууцны цахилгааны аюулгүй байдлыг хангаж, үр хүүхдийнхээ аюулгүй орчинг цаг ямагт бүрдүүлж байх чиглэлээр “Ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлье” сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэж, TBS телевизээр ард иргэдэд өдрийн 4 удаагийн давтамжтайгаар нийт 100 удаа хүргэн ажилласан.

Онцгой байдлын газрын 5200 дагагчтай фейсбүүк хуудсанд 32 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, веб сайтад сэрэмжлүүлэг мэдээг 6 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө зөвлөмжийг 3 удаа, байгууллагын үйл ажиллагаа, сургалт, хяналт шалгалт явуулсан талаарх мэдээ мэдээллийг 25 удаа нийт 11 удаагийн мэдээ мэдээллийг байршуулан иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

Газар хөдлөлт-2, Объектын гал түймэр-7, Мал, амьтны гоц халдвар өвчин-3, Эрэн хайх, ажиллагаа-12 нийт 24 дуудлага, мэдээлэлд онцгой байдлын газраас давхардсан тоогоор 122 алба хаагч, 19 техник, 2 эрэлч нохойтой ажиллаж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийг мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллав.

ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:

Аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх болон сумд дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж шүүх хуралд оролцож, Аймгийн Засаг даргын 56 захирамжийн хууль зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өглөө.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Зуунмод сумын Бүжинхэн цогцолбор цэцэрлэгийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэст албан шаардлага, Шүүхийн Тамгын газар, Зуунмод сумын Бүжинхэн цэцэрлэгт зөвлөмж хүргүүллээ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2000-2022 онд баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ хийж ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхөө больсон, хууль тогтоомжтой давхардсан зэрэг хүчингүй болгох шаардлагатай 26 тогтоолын

хэрэгжилтийг гаргаж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүллээ.

Аймгийн нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгийг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах журмын төсөл боловсруулах ажлыг хэсгийг байгуулан 27 суманд хэлэлцүүлэг, иргэд, олон нийтээс санал ажлыг зохион байгууллаа.

Аймгийн нутаг дэвсгэрт шашны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, байгууллагуудын судалгаа, мэдээллийг шинэчлэх ажлыг зохион байгуулж, Батсүмбэр суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа сүм, хийдийн үйл ажиллагаатай танилцаж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангууллаа.

Төв Баянжаргалан, Цээл сумын Засаг даргын Тамгын газрын эрх бүхий 6 албан тушаалтны үйл ажиллагаандаа хэрэглэдэг тамга, тэмдгийг шинэчлэх ажлыг зохион байгууллаа.

Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Хүүхэд эрхэм хэрэглэгч” 1 сарын хугацааны аяныг зарлан Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд “Эрүүл мэнд- Эрүүл хүнс” гар зургийн уралдааныг зохион байгууллаа.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын даргын баталсан 2023 оны 06 дугаар удирдамжийн дагуу өргөн хэрэглээний барааны үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Зуунмод суманд үйл ажиллагаа явуулж байгаа 13 хүнсний дэлгүүр, цэг салбарт хяналт шалгалт явуулж, зөвлөмж өглөө.

ТӨРИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР

Төрийн архивын эх баримтаас лавлагаа, хуулбар авах хүсэлт ирүүлсэн 109 иргэний хүсэлтийг хүлээн авч 751 хуулбар хувь олгож, 54 лавлагаа, 120 хөмрөгийн 543 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан үйлчилгээ үзүүлж орон нутгийн төсөвт 542,000 төгрөгийг орууллаа.

87 хадгаламжийн нэгжийн 1163 хуудас баримтын 6663 хүний нэр, 1163 заалтын тоо, 1163 тушаалын тоог мэдээллийн программд оруулж, 1163 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 1163 заалтын 1163 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ.

Баримтын нөхөн бүрдүүлэлтээр Сэргэлэн сумын “Огоот” ХХК, Сэргэлэн сумын “Тэнгэрхэнгэрэг” ХХК-ний шатахуун түгээх станцын 2023 оны 6 баримт, Зуунмод сумын Нотариатч Д.Намбарын 2022-2023 оны бүртгэл 44 баримт, нийт 2 хөмрөгийн 50 хадгаламжийн нэгжийг хүлээн авч, бүртгэлээ.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 66374 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138674 газар өмчлөх эрхийн 54431 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 923 /3 сард хүлээн авсан мэдүүлэг /923/

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 17,4 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 63,4 төгрөг, тэмдэгтийн хураамжаас 1,6 төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2962 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 90 нэмэлт өөрчлөлт, шинээр 45 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 1, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 18 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 22 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 60 лавлагаа өгч орон нутгийн төсөвт 10,4 сая төгрөгийг орууллаа.

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ сарын байдлаар 170 гэмт хэрэг бүртгэж өмнөх оны мөн үеэс 18,6 хувиар буурч, гэмт хэргийн илрүүлэлт 43,8 хувьтай байна.

Гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-6, шүүхээр баривчлагдсан-43, албадан саатуулсан-3, ар гэрт нь 17 иргэнийг хүлээлгэн өгч, нийт 69 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу биед эрүүл мэндийн үзлэг хийж, хүлээн авч ажиллалаа. Шүүхээр баривчлагдаж, хугацаа дууссан 46 иргэнээс 1,4 сая төгрөгийн төлбөр авч орон нутгийн төсөвт орууллаа.

Нийтийн хэв журам хамгаалах тасгаас 5 удаагийн арга хэмжээний хамгаалалтад давхардсан тоогоор 37 алба хаагч, 5 автомашин, 15 тусгай хэрэгсэл, 8 холбооны хэрэгсэл, ашиглаж 185 цагийн үүрэг гүйцэтгэж ажиллалаа.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд "Архи, согтууруулах ундааны эргэлт", "Электрон тамхины хор нөлөө" зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгууллаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замын хяналт шалгалтаар 6523 зөрчил илрүүлж, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 93 жолоочийг илрүүлэн тээврийн хэрэгслийг түр саатуулж, 75 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 18 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэвэрээр 7-30 хоног баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 89 жолоочийг илрүүлж, Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэлээ. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 6430 жолоочийг 189,6 сая төгрөгийн торгууль оногдуулж, зөрчил гаргасан 112 жолоочийн тээврийн хэрэгслийг түр саатуулж ажиллалаа.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Криминалистикийн шинжилгээ-23, магадлан шинжилгээ-57, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-116, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-191, гарын хээний санг дардсаар баяжуулсан-54, мөрөөр баяжуулсан-104, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-170, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-57, гистологийн шинжилгээ-57 тус тус хийгдлээ.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгд эл	Дунда ж хувь
3-р сар	309	135	4	440	85	355	19,3
	4857937.6	2100167.1	6816423.7	6816423.7	740572.9	607585 0.8	

ДӨРӨВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:

Төсвийн орлогын талаар:

2023 оны 02 сарын байдлаар орон нутаг 3368.4 сая төгрөг төвлөрүүлэхээс 5436.7 сая төгрөг төвлөрүүлж 161.4 хувьтай, 2068.2 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давсан. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 342.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 649.4 сая төгрөг төвлөрүүлж 189.6 хувьтай, 306.8 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 7498.9 сая төгрөгөөр биелж, 164.3 хувьтай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөг биелүүлсэн 15 сум байна. Үүнд: Архуст, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Баянхангай, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Заамар, Мөнгөнморьт, Өндөрширээт, Сэргэлэн, Сүмбэр, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Батсүмбэр, Баянжаргалан, Баянцагаан, Бүрэн, Дэлгэрхаан, Жаргалант, Лүн, Угтаал, Зуунмод зэрэг 11 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баян сум байна. 3 шатны орлогын төлөвлөгөө тасалсан сум байхгүй.

Төсвийн зарлага, санхүүжилтийн талаар:

Аймгийн төсвөөс 2023 оны 02 дугаар сарын байдлаар нийт 4933.0 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн төсвийн байгууллага болон 27 суманд олгосон. Зарлагыг салбараар авч үзвэл:

Боловсрол, шинжлэх ухааны байгууллага 3192.8 сая төгрөг

Эрүүл мэндийн байгууллага 217.2 сая төгрөг

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбар 3712.1 сая төгрөг

Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд 1558.6 сая төгрөг, нийт 8680.8 сая төгрөгийн зарлага гаргаад байна.

Өр, авлагын талаар:

2023 оны 02-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 208,5 сая төгрөгийн авлага, 324.5 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 273.9 сая төгрөг буюу 84.4 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 1.1 сая төгрөг буюу 0.4 хувь нь цалингийн өглөг, 7.0 сая төгрөг буюу 2.2 хувь нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр, 20.1 сая төгрөг буюу 6.2 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 22.1 сая төгрөг буюу 6.8 хувийг бусад өр эзэлж байна

ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Зуунмод хотын дулаан хангамж, цэвэр усан хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, нийтийн орон сууцны доторхи шугам сүлжээнд засвар, шинэчлэл хийх ажлын эрэмбэ дарааллыг тогтоох аймгийн Засаг даргын А/10 захирамжийн дагуу ажлын хэсэг шугам сүлжээний эрэмбэ дарааллыг тогтоон Зуунмод сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2023 оны 07 захирамжаар Төв аймгийн Лүн сумын цэвэрлэх байгууламжийн ашиглалт, эвдрэл гэмтэлд үнэлэлт, дүгнэлт, санал өгөх ажлын хэсэг байгуулж ажиллав.

Архитектур төлөвлөлтийн даалгавар боловсруулах баталгаажуулах ажлын хүрээнд нийт 2023 онд 18 архитектур төлөвлөлтийн даалгавар баталж, 6 архитектур төлөвлөлтийн даалгавар олгосон.

Барилга, инженерийн байгууламжийн зураглалыг шалгаж, хот байгуулалтын мэдээллийн санд 10 гүйцэтгэлийн зураг хүлээн авч акт олгосон ба энэ сард 4 гүйцэтгэлийн зураг хүлээн авсан.

2023 онд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 33 төсөл арга хэмжээ 61,83 тэр бум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил захиалагчийн чиг үүргийг гүйцэтгэн ажиллаж байна. Үүнд: Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлуудаас 10 хөрөнгө оруулалтын ажилд худалдан авах ажиллагааг зарлахаар төлөвлөн 3 ажил гэрээ байгуулах шатандаа, тендер зарлах шатандаа байгаа 7 төсөл арга хэмжээ байна.

Гэрээ байгуулсан:

1. Аймгийн нутгийн удирдлагын ордны өргөтгөл, их засварын ажлыг эхлүүлэх
2. Цэнгэлдэх хүрээлэнгийн барилдааны талбайд таримал хуйлмал зүлэг суурилуулах
3. Нийтийн зориулалттай орон сууцны подвалын бохирын шугам сүлжээг шинэчлэх /Зуунмод сумын 19, 20, 21, 22-р байр/

Тендер зарлах шатандаа:

4. Нийтийн зориулалттай орон сууцны барилгын гэрэлтүүлгийн ажил /16, 17, 18, 19, 20, 21, 22, 101, 1, 27, 40, 41, 42, 46, 47, 48, 25, 201, 400, 501, 502, 111/
5. Нийтийн орон сууцны төв магистрал шугам сүлжээнүүдийг шинэчлэх /16, 17, 18-р байр/
6. Аймгийн Залуучуудын ордны дээврийн их засвар
7. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн сүүдрэвч хийх
8. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн явган зам талбайн шинэчлэлт
9. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна дотор тойрог замыг асфальтаар хучих
10. Нийтийн тээвэр-Зуунмод төсөл хэрэгжүүлэх

Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлууд бүгд он дамжсан барилга байгууламжууд байна.

“Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох болон ашиглалтад оруулах” дүрмийн хүрээнд :

- Барилга эхлүүлэх зөвшөөрөл энэ онд нийт 9 барилга байгууламжид олгон энэ сард 5 барилга байгууламжид олгосон.
- Барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааны хүрээнд энэ онд нийт 4 барилга байгууламжийг ашиглалтад оруулсан ба энэ сард 2 барилга байгууламж ашиглалтад орсон.

ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг Баянцогт сум 3 нэгж талбар, Жаргалант сум 15 нэгж талбар, Баянчандмань сум 3 нэгж талбар нийт 21 нэгж талбарын дуудлага худалдааг газрын биржийн www.mle.mn сайтад баталгаажуулж, зарласан.

Газрын биржийн цахим системд бүртгэлтэй 29216 нэгж талбарт газрын төлбөрийн ногдуулалт нэхэмжлэлийг үүсгэсэн. Мөн өмчилсөн газрын татварыг 72056 нэгж талбарт үүсгэж татварын удирдлагын нэгдсэн систем рүү илгээсэн.

Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд 27 сумын 2023 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээний 11950 нэгж талбар бүрээр оруулж сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг цахимд системд оруулсан.

Зуунмод суманд зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх мэдэгдлийг 148 амбаар, контейнерууд 14 хоногийн хугацаатай наасан. Зуунмод сум Жишиг хороололд өргөдлийг дагуу өмчлөлийн газар дээр хяналтын хэмжилт хийж зураглал гаргасан.

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 22,546.4 сая төгрөгийн 78 төсөл, хөтөлбөр, арга хэмжээг тусган баталж үүнээс 17,103.7 сая төгрөгийн 62 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнд: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2023 онд зарлахаар 17,103.7 сая төгрөгийн 62 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг нь зохион байгуулахаар шийдвэрлэсэн. Үүнд:

1. Орон нутгийн өмчийн газарт тендер шалгаруулалт зарлах 12,237.4 сая төгрөгийн 27 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ;

2. Сумдад эрх шилжүүлж, сумын ЗДТГ-т тендер шалгаруулалт зохион байгуулах 4,886.3 сая төгрөгийн 35 төсөл, арга хэмжээ.

Аймгийн орон нутгийн өмчийн газарт зарлах тендер шалгаруулалтын явц:

2023 онд 12,237.4 сая төгрөгийн 27 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд ОНӨГ-аас тендер зарлахаас 03 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 9,027.4 сая төгрөгийн 14 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд үнэлгээний хороо байгуулагдаж тендерийн явц 52 хувьтай. Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгосон

1. Нийтийн орон сууцны төв магистрал шугам сүлжээнүүдийг шинэчлэх (Зуунмод 19, 20, 21, 22 байр), төсөвт өртөг 120.0 сая төгрөгийн 1 ажлын гэрээ байгуулах эрхийг захиалагч аймгийн ГХБХБГ-т хүргүүлсэн;

Үнэлгээний хороо үнэлгээ хийж буй

1. Цэнгэлдэх хүрээлэнгийн барилдааны талбайд таримал хуйлмал зүлэг суурилуулах, 200.0 сая төгрөгийн ажил;

Зарласан тендер

1. Баянхошуу баг чиглэлийн авто зам (Зуунмод), 2,334.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2023 онд 500.0 сая төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэх ажил;

2. Аймгийн залуучуудын ордны дээврийн засвар, 42.3 сая төгрөгийн ажил;

3. Төв цэнгэлдэх хүрээлэнд сүүдрэвч хийх, 442.3 сая төгрөгийн ажил;

4. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна, дотор тойрог замыг асфальтаар хучих, 320.0 сая, төгрөгийн ажил;

5. 100 өрх-100 гэр төсөл, 260.0 сая, төгрөгийн ажил;

6. Нийтийн зориулалттай орон сууцны гэрэлтүүлгийн ажил (16, 17, 18, 19, 20, 21, 101, 1, 27, 40, 41, хойд 46, 47, 48, 25, 201, 400, 501, 502, 111), 160.0 сая төгрөгийн ажил;

7. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, 27 сумын 2023 оны эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах, 3,500.3 сая, төгрөгийн ажил;

Тендер зарлахаар ҮХороо ТББичиг боловсруулж буй

1. Нийтийн орон сууцны төв магистрал шугам сүлжээнүүдийг шинэчлэх (16, 17 байр), 100.0 сая, төгрөгийн ажил;

2. Төв цэнгэлдэх хүрээлэнгийн явган зам талбайн шинэчлэл, 442.3 сая, төгрөгийн ажил;

3. Монгол өв соёлын цогцолбор байгуулах төсөл, хэрэгжүүлэх зардал 1,000.0 сая, төгрөгийн ажил;

4. Төв аймаг-100 гэрлэн чимэглэл төсөл (Лүн, Баянчандмань, Эрдэнэ, Баян, Зуунмод сум), 240.0 сая, төгрөгийн ажил;

5. Ангилан ялгах хогийн савыг нэмэгдүүлэх, 68.0 сая, төгрөгийн ажил.

Сумдад эрх шилжүүлж, сумын ЗДТГ-т тендер шалгаруулалтын явц:

2023 онд 4,886.3 сая төгрөгийн 35 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд сумдад тендер зарлахаас 03 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 2,112.3 сая төгрөгийн 4 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд үнэлгээний хороо байгуулагдаж тендерийн явц 11 хувьтай. Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгосон

1. Борнуур сумын цэцэрлэгийн их засвар, төсөвт өртөг 100.0 сая төгрөгийн 1 ажлын гэрээ байгуулах эрхийг захиалагч сумын Засаг даргад хүргүүлсэн;

Зарласан тендер

1. Эрдэнэсант сумын Соёлын төвийн их засвар, 492.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил;

2. Сэргэлэн сумын Дунд сургуулийн барилгын их засвар (аймаг-200.0 сая, сум-150.0 сая) хамтарсан санхүүжиттэй, 350.0 сая, төгрөгийн ажил;

3. Эрдэнэ сумын дотор замын их засвар (Сумын төвийн тоосжилтыг бууруулах, хөрсийг хамгаалах зорилгоор зам тавих), (аймаг-200.0 сая, сум-970.0 сая) хамтарсан санхүүжилттэй, 1,170.0 сая төгрөгийн ажил.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 06 сарын 26-ын өдрийн 52 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 07 сарын 20-ны өдрийн А/396 дугаар захирамжаар хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох санал, холбогдох баримт бичиг, өмч хамгааллах байнгын зөвлөлийн дүгнэлт хурлын тэмдэглэлийг тус тус судлан үзэж өссөн дүнгээр нийт эхний улирлын байдлаар 15 байгууллагын 850.0 сая төгрөгийн хөрөнгийн үнэ болон хугацааг шинэчлэн тогтоосон.

Эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын архивын баримтыг орон нутгийн өмчит болон өмчийн оролцоотой 170 байгууллагаас авч хяналтын хуудсыг баталгаажуулан архивын нэгж үүсгэж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 14 дүгээр хуралдааны 08, 09 дүгээр тогтоолоор худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн 23 нэр төрлийн тээврийн хэрэгслийн дуудлагын худалдааг зохион байгуулсан.

Аймгийн “Түрээсийн орон сууцны сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ын хүрээнд 2018 онд түрээсийн 12 өрх, 2019 онд 13, 2021 онд 1 өрх нийт 26 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулснаар сарын график хугацааны төлөлтөд хяналт тавьж ажилласнаар 2023 оны 03 сарын 23 ны байдлаар нийт 14.000,000 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Угтаал-Цайдам сумын ХААДС-ийн хүсэлтийн дагуу силост хадгалагдаж байгаа 2063 тн үрийн улаанбуудайнаас 15 дээжийг авч Стандарт хэмжил зүйн лабораторид тарих үрийн чанарын шинжилгээнд хамруулсан

Мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох зорилгоор нийт сүргийг ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх зорилгоор аймгийн хэмжээнд нийт үхэр сүргийг хавар, намрын технологит хугацаанд дахин давтагдашгүй дугаар бүхий ээмгээр ээмэглэн, бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг даргын албан үүргийг сумын Засаг даргад хүргүүлэв.

Оны эхний байдлаар 2372086 толгой эх мал төллөхөөс 3 дугаар сарын 22-ны байдлаар нийт төллөх хээлтэгчийн 3.4 хувь буюу 79619 толгой мал төллөж, 79210 төл бойжиж, төл бойжилт 99.5 хувьтай байна. Том малын зүй бус хорогдлоор нийт мал сүргийн 0.5 хувь буюу 26671 толгой мал хорогдоод байна. Үүнд: адуу 1546, үхэр 1925, хонь 12688, ямаа 10510, тэмээ 2 толгой тус тус хорогдсон мэдээтэй байна.

Малчдад зориулсан сургалт зөвлөгөөн зохион байгуулсан Цээл, Баянжаргалан, Зуунмод сумын ЗДТГ-тай хамтран ажиллаж, “Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдвээр мэдээлэл сургалтыг зохион байгуулав. .

Аймгийн Засаг даргын А/191 тоот захирамжаар “Төв түмний аварга малчид”-ыг алдаршуулах, “Малчдын анхдугаар аян”-ыг өрнуулэх уулзалт, зөвлөгөөн, сургалтыг зургаан бүсэд зохион байгуулах бэлтгэл хангасан.

Мал аж ахуйн хаваржилтын хүндрэлийг даван туулах, болзошгүй эрсдлээс хамгаалах зорилгоор аймгийн Засаг даргын А/160 тоот захирамжаар “Аймгийн аюулгүй нөөц”-д байгаа 50 тн өвсийг өөрийн үнэ болох 9740 төгрөгөөр малчдад борлуулсан.

ХХААХҮЯ-ны сайдын 2023 оны А/37 дугаар тушаалаар ЖДҮХС-аас манай аймагт 900.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэхээр батлагдаж олон нийтийн мэдээлэлийн хэрэгсэлээр иргэдэд зар хүргэн нийт 4.5 тэр бум төгрөгийн 27 төсөл ирүүлснийг ХХААГ-ыг даргын А/11 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн 1-р шатны шалгаруулалт болох иж бүрдэл шалгах ажлыг зохион байгуулан 1.5 тэр бум төгрөгийн 9 төслийг дараагийн шатанд шилжүүллээ.

Хөгжлийн шийдэл “БЭСТ” төсөлтэй хамтран “Хоршооны санхүүгийн тайлан гаргах” чиглэлээр сургалтыг Улаанбаатар хотод зохион байгуулан нийт 11 сумын 48 хоршооны төлөөлөл 57 иргэн хамрагдлаа.

2023 оны хаврын тариалалтын бэлтгэл хангах ажлын хүрээнд сумдад чиглэл зөвлөмж өгч техник засварын мэдээ тайлан авч эрчимжүүлж ажиллаж байна.

Сумдын 2022 оны агротайлангаар ирсэн мэдээлэлд тусгагдсан ХАА-н техник тоног төхөөрөмж, 2023 онд Аймгийн засаг дарга, сумдын засаг дарга нартай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ, 2023 оны аймгийн Газар тариалангийн үйлдвэрлэлийн

төлөвлгөөг үндэслэн хаврын тариалалтын хугацаа, ажиллах хүч, шатах, тослох материалын тооцооллыг гарган бэлтгэл хангуулах ажлыг зохион байгуулж байна.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дэргэдэх баталгаажуулалтын орон тооны бус зөвлөлийн хуралдаанаар тохирлын үнэлгээнд 17 газар хамрагдсанаас 14 үйлчилгээний газар давтан үнэлгээнд, 3 үйлчилгээний газар нь анхан шатны үнэлгээнд хамрагдан тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олгосон..

СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:

Тохирлын үнэлгээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн Зуунмод, Сэргэлэн сумдын 11 аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүн үйлчилгээг холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээнд хамрууллаа. Тохирлын үнэлгээнд хамрагдах хүсэлт ирүүлсэн Зуунмод, Баянчандмань, Баянхангай, Сэргэлэн сумын 12 иргэн, аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүн үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулсан.

Баталгаажуулалтын орон тооны бус зөвлөлийн 03 дугаар хурлын шийдвэрийг үндэслэн 17 аж ахуйн нэгж иргэний 10 худалдаа, 1 нийтийн хоол, 2 караоке баар, 1 ресторан, 2 амралтын газар, 1 халуун усны үйлчилгээнд тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаагаар шинээр олгох сунгах үйлчилгээ үзүүлэв.

Массын хэмжлийн төрлөөр Зуунмод, Сэргэлэн сумын худалдаа үйлчилгээ, нийтийн хоол үйлдвэрлэлийн 69 ш массын хэмжих хэрэгслийг шалгаж баталгаажуулсан.

Итгэмжлэгдсэн лаборатори нь 82 сорьцыг хүлээн авч 251 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулсан. Үүнээс ургамлын эрүүл ахуй хорио цээрийн шинжилгээгээр 5 сорьц цэвэршилтээр, 4 сорьц хог ургамлаар, 1 сорьц соёололтоор, нян судлалын шинжилгээгээр гурилан бүтээгдэхүүний 3 сорьцод эшериха коли, илэрч стандартын шаардлага хангаагүй.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын 2023 оны 02 дугаар албан даалгаварын хүрээнд Аймгийн Засаг даргын 2023 оны 03 сарын 01-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар гарч, аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Гуравдугаар сард зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээнд нийт 194 төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, 2800 иргэн оролцож, 467тн хог хаягдлыг цэвэрлэн, төвлөрсөн хогийн цэгт хүргүүллээ. Иргэдийн аюулгүй байдлыг хангах, хөрсний бохирдол, халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж 434 эзэнгүй нохой, 413 малын сэг зэмийг халдваргүйжүүлэн, устгалаа.

"Жорлон" арга хэмжээний хүрээнд 6 нүхэн жорлонг буулгав.

Ахуйн хүрээнээс гардаг аюултай хог хаягдлыг иргэдэд таниулах, хүрээлэн буй орчинд үзүүлэх хор аюулыг бууруулах зорилгоор зохион байгуулсан "Аюулыг авдарлая-2" аянд нэгдэж, дууссан зай хураагуур, эвдэрсэн гар утас, хугацаа дууссан эм зэргийг цуглуулж, нэгдсэн тайланг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороонд хүргүүлэв.

Аймгийн 15 сумын 18 сургууль энэхүү аянд оролцож, дууссан батерей 512 кг, эвдэрсэн гар утас болон түүний баттерей 129.6 кг, утастай цэнэглэгч 204 кг, хугацаа дууссан эм 19.26 кг, бусад төрлийн электрон хаягдал 146.1 кг нийт 1тн 11.5 кг аюултай хог хаягдлыг авдарласан байна.

Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/124 дугаар захирамж, хяналт шалгалт хийх ажлын хэсгийн удирдамжийн дагуу ажлын хэсэг Батсүмбэр, Борнуур, Жаргалант, Баянчандмань, Баяндэлгэр, Эрдэнэ, Мөнгөнморьт сумдад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулав. Хяналт шалгалтаар 5 сумын 13 аж ахуйн нэгж байгууллагын талбай тусгаарлалт, ойн цэвэрлэгээ, мод бэлтгэлийн ажлыг газар дээр нь шалгаж, Ойгоос мод бэлтгэх талбай тусгаарлахад тавих ерөнхий шаардлага MNS 6840 : 2020, Ойн арчилгаа, цэвэрлэгээ, үйлдвэрлэлийн ашиглалтын огтлолтод тавих ерөнхий шаардлага MNS 6447:2020 стандарт, хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж буй эсхэд хяналт тавьж ажиллаа.

Мөнгөнморьт сумын нутаг дэвсгэрээс байгалийн дагалт баялаг (Хуш модны самар)-ийг ашиглах хугацаа дууссан, гарал үүслийн гэрчилгээгүй хууль бусаар тээвэрлэсэн зөрчлийг илрүүлж 5030 кг самрыг саатуулж, Мөнгөнморьт сумын цагдаагийн хэсэгт шилжүүлэн зөрчлийн хэрэг үүсгүүлэн шалгуулж 3,000,000 төгрөгийн торгууль ноогдуулж төлүүлсэн.

Мөнгөнморьт сумын Хөгшчүүлийн хорооллийн орчмоос хууль бусаар 2.8 М³ хэрэглээний нойтон мод бэлтгэн тээвэрлэсэн зөрчлийг илрүүлж экологи эдийн засгийн үнэлгээг газар дээр нь гаргаж Мөнгөнморьт сумын экологийн цагдаагийн албанд шилжүүлж, эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулж байна

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Тэнүүн гэх газраас “Модон цаг” ХХК нь хуш мод бэлтгэн, гарал үүслийн гэрчилгээгүй орон нутаг дамжуулан тээвэрлэсэн зөрчлийг илрүүлж Мөнгөнморьт сумын экологийн цагдаагийн албанд шилжүүлэн шалгуулж байна.

“Гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам” батлах тухай Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2013 оны 153 тушаалын хэрэгжилтийг хангуулах зорилгоор шөнийн эргүүл шалгалтын ажлыг Баянчандмань суманд зохион байгуулж, Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр, Шаамар сумдаас гарал үүслийн гэрчилгээнд бичигдсэн хэмжээнээс хэтрүүлэн тээвэрлэсэн 4 авто машиныг саатуулан шалгаж, тээвэрлэлт хэтрүүлсэн 4,5 м³ нарсан палкийг орон нутгийн орлогод хураан, 4 иргэнд 200000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ ноогдуулан шийдвэрлэсэн. Мөн гарал үүслийн гэрчилгээнд засвар хийж хууль бусаар мод бэлтгэн тээвэрлэсэн 1 иргэнийг саатуулан эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар экологийн цагдаагийн албанд шилжүүлсэн.

Баян-Өнжүүл сумын нутагт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч Миндуотай ХХК-нд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүй, ус ашиглуулах дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулаагүй, уурхайн амнаас шүүрлийн усыг шавхалт хийх үед тунаах нуурын далан сэтэрсэн ус шавхаж буй хоолойд тоолуур байршуулж баталгаажуулаагүй зэрэг зөрчил дутагдлыг илрүүлж түүнийг арилгуулахаар улсын байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

УС, ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

Урьдчилан мэдээлэх:Нарийвчилсан мэдээ,1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7,10 хоног тутмын цаг агаарын тойм гаргаж И-мэйл-ээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр, нарийвчилсан сэрэмжлүүлэг мэдээ 09, 13, 21-ний өдрүүдэд, хоногийн сэрэмжлүүлэг мэдээг 12, 20-ны өдөр тус тус 3 удаа цасан шуурганы сэрэмжлүүлэг мэдээг гаргаж И-мэйл-ээр дамжуулж, www.tuv.tsag-agaar.gov.mn сайт, TuvTsaguur page-д байршуулан ард иргэдэд үйлчилсэн.

Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 03 дугаар сарын 23-ний өдрийн байдлаар нийт 48 удаа ажиглалт хийсэн ба хүхэрлэг хийн багаж эвдэрсэн тул хэмжилт хийгдэхгүй байгаа азотын давхар ислийн дундаж агууламж 0.014 мг/м³ үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад азотын давхар ислийн дундаж агууламж 0.008мг/м³-ээр буурсан үзүүлэлттэй байна.

Гадаргын усны чанар: Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 03 дугаар сард Туул-Лүн, голын хяналт шинжилгээг хийхэд цахилгаан дамжуулах чанар нь Туул-Лүн 424 uS/cm, гарлаа.

Ус судлалын салбар: Төв аймгийн нутаг дэвсгэрт 7-н ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2023 оны 03 дүгээр сарын 21-ний байдлаар усны түвшин: Хэрлэн гол Хэрлэн-Хонгон 118 см, Хэрлэн-Мөнгөнморьт 129 см, Туул гол Туул-Алтанбулаг харуулд 550 см, Туул-Лүн харуулд 166 см, Туул-Заамар харуулд-166 см тус тус байсан ба өмнөх оныхтой харьцуулахад усны түвшин Хэрлэн голын дагуух Хэрлэн-Мөнгөнморьт харуул 69 см бага, Туул голын дагуух Туул- Алтанбулаг харуул 8 см бага, Туул-Лүн харуул, Туул-Заамар харуулууд 11-17 см их, Сөгнөгөр голын дагуух Сөгнөгөр-Сөгнөгөр харуул, Шивэрт голын дагуух Шивэрт-Борнуур харуулууд ёроолдож хөлдсөн. Голуудын мөсний зузаан 40-117 см харилцан адилгүй байна. Голуудын мөсний зузаан харилцан адилгүй байгаа тул томоохон голын мөсөн дээгүүр тээврийн хэрэгсэлтэй зорчихгүй байхыг анхааруулж байна.

МАЛ, АМЬТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1023.0 мян.тол мал, амьтан хамруулаар төлөвлөн эм биобэдмэлийн татан авалт 53.3 хувьтай байна.

Баянжаргалан сумын Улаан ухаа 2 багийн Хүйсийн худаг гэх газарт малчин Б.Сайнбаяр, 1-р багийн малчин М.Ариунболд нарын сууриас бог малын мялзан өвчин оношлогдож хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоон 03 дугаар сарын 22-нд тайван байдалд шилжсэн. Голомтод 2 өрхийн 1162 малыг үзлэгт хамруулан 70 мал өвчилж түүнээс 5 мал үхэж, 32 мал устгаж, 33 малын шинж тэмдэг бүрэн арилсан байна. Голомтын болон устгалын цэгийн 3800 м² талбайд халдваргүйтгэл хийсэн байна.

Баянцогт сумын гуна багийн Хонгор гэх газарт хонины цэцэг өвчин оношлогдож с2 өрхийн 528 малыг үзлэгт хамруулан 25 мал өвчилж түүнээс 2 мал үхэж, 8 мал устгаж, 15 малын шинж тэмдэг арилсан. Голомт бүхий суманд хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоон ажиллаж 03 дугаар сарын 19 нд тайван байдалд шилжэн 4500 м2 талбайд халдваргүйтгэл хийлээ.

Зүй бусаар хорогдсон 25099 толгой малын сэг зэмийг булж устгалаа. Халдваргүйтгэл хийхээр 27 сумын мал эмнэлгийн тасагт 160 кг суперкилл олгов. Үйлдвэрт нийлүүлж буй түүхий сүүнд 3446 мал эмнэлгийн гэрчилгээг олгож ажилласан.

Амьтан хэрэгцээлэх-225, бүтээгдэхүүн-1394, отор нүүдэл-272, үржил-248, алдуул мал 1 нийт 2140 мал эмнэлгийн гэрчилгээг олгож, 177 дуудлагын дагуу үйлчилгээ үзүүллээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хяналтын цэг 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа нийт 126 тээврийн хэрэгсэл, адуу 283, үхэр 30, хонь-378 ямаа-101 нийт 792 толгой амьд мал, адууны мах-3270 үхэр мах-36150 кг, хонь мах-49580 кг, ямаа мах-77103 нийт-166103 кг, Дайвар бүтээгдэхүүн-11508кг, Ноос-19000 тн, Тэмээ шир-430, Адууны шир-878ш, Үхрийн шир 754ш, нэхий-9000ш, ямааны арьс-1375ш нийт-12437 ширхэг арьс ширэнд эрүүл ахуйн үзлэг хийн нийт-146 мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж ажиллалаа.

ЗУРГАА. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Алдарт эхийн 1, 2 дугаар зэргийн одон авах 27 сумын 307 эхийн материалыг хүлээн авч, баримтын бүрдэлд хяналт хийн, 3 эхийн материал журмын шаардлага хангаагүй хасагдаж, нийт 27 сумын 304 эхийн материалыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Миний сайхан ээж 1000”-хүндэтгэлийн арга хэмжээг ТББ-тай хамтран зохион байгууллаа.

Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд “ТӨВ-100 OPEN-2023” шатрын тэмцээнийг 2023 оны 03 дугаар сарын 10-12-ны өдрүүдэд зохион байгуулж 41 багийн 489 тамирчид оролцлоо.

Эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулагдан, НБХ-ийн дарга “Эрүүл мэндийн салбарт 2023 онд анхаарах асуудал, орон нутгийн хамтын ажиллагаа” сэдвээр Эрүүл мэндийн салбарын удирдлагуудад мэдээлэл танилцуулан, үүрэг чиглэл өглөө. Тус зөвлөгөөнд АНЭ, 27 сумын ЭМТ-ийн удирдлагууд нийт 43 алба хаагчид хамрагдлаа.

Нийгмийн салбарын явуулын үйлчилгээний хүрээнд АНЭ-ийн нарийн мэргэжлийн эмч нарын “Нүүдлийн амбулатори”-ийн үзлэг Жаргалант, Борнуур, Сүмбэр сумдад зохион байгуулж 3 сумын 1141 иргэнийг үзлэг, оношилгоонд хамрууллаа.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр “Харилцан хүндэтгэе” үндэсний аянд нэгдэн 27 сумын төрийн байгууллага, агентлаг байгууллага, иргэдэд жендэрийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж тайланг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлж ажиллалаа.

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө (2022-2031)”-г үндэслэн аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөний төслийг боловсруулан хэлтэс, агентлаг байгууллагуудад хүргүүлсэн.

“Төв математик VIII” олимпиадыг Заамар сумын I сургуульд 2023 оны 03 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд АЗДТГ, БШУГ-тай хамтран зохион байгуулж 22 сумын 25 сургууль, 26 багийн 65 багш, 220 сурагч оролцлоо.

Нийгмийн даатгалын чиглэлээр

Хаан, Төрийн банкаар дамжуулан 17902 тэтгэвэр авагчдад 8,8 тэрбум төгрөгийн тэтгэврийг олголоо.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 17 өргөдөл, 16 албан бичгийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өглөө. НДШ дутуу тооцсон зөрчилд 16 ААН, байгууллагад 3,6 сая төгрөгийн УБАкт тогтоож 100 хувь барагдуулсан.

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК 2 удаа хуралдаж, нийт 101 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 10 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 68 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 1 иргэнийг дахин онош тодруулахаар буцааж, 3 иргэний хөдөлмөрийн чадвар алдсан хувь, хэмжээ тогтоосон актыг цуцаллаа.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний чиглэлээр

Нийгмийн халамжийн тэтгэвэр 1860 иргэнд 1559,7 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1153 иргэнд 312,0 сая төгрөг, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 4 иргэнд 4,8 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тусламж 287 иргэнд 246,1 сая төгрөг, алдарт эхийн одонтой 9423 иргэнд 1215,5 сая төгрөг, ахмад настны хөнгөлөлт тусламжид 2792 ахмад настанд 70,9 сая төгрөг, Насны хишиг 5852 иргэнд 475,5 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжид 320 иргэнд 34,2 сая төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 2337 иргэнд 80,6 сая төгрөг, жирэмсэн 791 эхэд 70,9 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсны тэтгэмж 3922 иргэнд 539,6 сая төгрөг, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж 301 иргэнд 165,8 сая төгрөг, ихэр хүүхдийн тэтгэмж 6 иргэнд 12 сая төгрөг, Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 32885 хүүхдэд 9816,8 сая төгрөг тус тус олголоо.

“Төгсөлтийн аргачлал” төсөл хөтөлбөрт 2023-2024 онд хамрагдах 457 өрхийг сонгож, 10 төрлийн судалгаа гарган мэдээллийн сан бүрдүүллээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурал 3 удаа хуралдаж, 10 хүүхдийг асуудлыг хэлэлцсэнээс 5 хүүхдийн байнгын асаргааг сунгаж, шинээр 5 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлж, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэлээ.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 409 өрхийн 1070 иргэн 1140 хүүхдэд 26,2 сая төгрөгийн 10-н нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн олгож хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийллээ.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн Ejob программд 03 дугаар сарын байдлаар 69 ажил олгогч, 120 иргэн ажил хайгчаар бүртгэгдэж, 31 ажил олгогчийн 80 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 22 иргэнийг ажилд зуучиллаа.

ХХҮГ-аас Аймгийн ЗДТГ, Мөнхийн баян гал ХХК, аймгийн Цагдаагийн газар, Төрийн банкинд ажилд орох хүсэлтэй нийт 7 иргэний хүсэлтийг хүлээн авч ажилд зуучлах мэдэгдэл хүргүүллээ.

Зуунмод сумын 5-р багийн иргэдийн нийтийн хуралд оролцож залуучуудын загвар төв, Ejob систем, жижиг зээл, төсөл хөтөлбөрүүдийн талаар нийт 240 иргэнд мэдээлэл хүргэж, ажлын байрны нээлттэй өдөрлөгийн зохион байгуулан 3 иргэнийг байнгын ажлын байранд зуучиллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан: 186 иргэний 50261,05 мянган төгрөгийн эргэн төлөлтийг ХЭДСанд төвлөрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн ажлын байрны төлбөрт 19740,0 мянган төгрөг ХЭДСанд төвлөрүүллээ.

Түүхт ой аймаг, сумдад тохиож байгаатай холбогдуулан орон нутгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийтийн эзэмшлийн гудамж зам, талбайн шинэ бүтээн байгуулалт, тохижилт, байгалийн эрсдлээс үүдсэн хор хохирлыг арилгах, бууруулах чиглэлээр 12 сумаас төсөл ирүүлснийг судлан ажлыг эхлүүлэх чиглэлийг өглөө. Дээрх төслүүдийн хүрээнд нийт 140 иргэн түр ажлын байраар хангагдана.

Банкаар дамжуулан олгогдох “Жижиг зээл”-ийн арга хэмжээнд хамрагдахыг хүссэн иргэдийг бүртгэж, зээлийн өмнөх сургалтыг “Төсөл боловсруулах” чиглэлээр цахим болон танхимаар нийт 50 гаруй иргэдийг хамруулан зохион байгууллаа. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн банкаар дамжуулан олгох жижиг зээлийн хороо хуралдаж Жаргалант, Баянчандмань сумын 3 иргэн, Баянцагаан сумын 1 хоршоонд нийт 56,0 сая төгрөгийн зээлийг олгож, шинээр 4 ажлын байр бий болж, 6 ажлын байрыг хадгалагдлаа. Өссөн дүнгээр нийт 17 иргэнд 296,0 сая төгрөг, 1 хоршоо, 1 ААНБайгууллагад 51,0 сая төгрөг нийт 347,0 сая төгрөгийн зээлийг Төрийн банкаар дамжуулан олгож, 27 шинэ ажлын байр бий болж, 39 ажлын байр хадгалахаар ажлын байрны гэрээг төсөл хэрэгжүүлэгчидтэй байгууллаа.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж анхдугаар хуралдааныг зохион байгууллаа. Хуралдаанаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн хөтөлбөрийг 2023-2025 онд хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөний төслийг аймгийн ЗД-н зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлахаар шийдвэрлэв.

“Эрүүл аюулгүй ажлын байрыг эрхэмлэгч байгууллага” шалгаруулах улсын уралдаанд Баянчандмань сумын Ерөнхий боловсролын сургууль, Политехник коллежийн материалуудыг ХАБЭА-н салбар зөвлөлийн даргын 01/420 дугаартай албан бичгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд хүргүүлсэн.

Улирлын чанартай барилга, уул уурхай, газар тариалангийн ажил эхэлж байгаатай холбогдуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн

хэрэгжилтийг хангуулж, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын Засаг дарга нарт Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын 93 дугаар албан бичгээр 28 заалт бүхий зөвлөмж хүргүүлээд байна.

Үйлдвэрлэлийн осол гарсан 4 ААНБ-ын ХАБЭА-н ажилтнуудад ослын акт тогтоох, бүрдүүлэх материалын талаар зөвлөгөө мэдээлэл өглөө.

Сумдын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 28,29-ний өдрүүдэд зохион байгуулж 2023 оны зорилт чиг үүргийг танилцуулж, арга зүйн зөвлөмж чиглэл өгч ажиллав.

Холт Интернэйшнл ОУБ-ын санхүүжилтээр хамтран хэрэгжүүлдэг “Хүүхдийн амьжиргаа дэмжих” төсөл хөтөлбөрт хамрагддаг 50 хүүхдийн 03 дугаар сарын 2,6 сая төгрөгийн хүүхдүүдийн данс руу бүрэн шилжүүллээ.

Эрүүл мэндийн салбарын хүрээнд:

Аймгийн хэмжээнд 2023 оны 02 дугаар сард 136 эх төрж өнгөрсөн оны мөн үеэс 24 тохиолдлоор өссөн ба 137 нярай бүртгэгдсэн. Жирэмсний хяналтад нийт 720 эх үүнээс 201 жирэмсэн эхийг шинээр хяналтад авч, эхний 3 сартай хяналтад 93.53% нь хамрагдсан. Нийт 51949 хүнд үзлэг хийсэн, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 10830, амбулаторийн үзлэг 34566, идэвхтэй хяналтаар 3769 хүнд үзлэг хийсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 2853 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Эмнэлэгт 3002 хүн эмчлэгдэн нийт 21233 ор хоног ашигласан. Дундаж ор хоног 7,1 байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Баянцогт, Баян, Дэлгэрхаан сумын Эрүүл мэндийн төв, Замтын булаг, Арга билэг сувилал нийт 6 байгууллага магадлан итгэмжлэлд хамрагдлаа.

Дэлхийн эмч нарын баярын өдрийг угтан зохион байгуулсан спортын 4 төрөлт тэмцээнд 200 гаруй эмч, онол практикийн бага хуралд 16 эмч, Эмч зөвлөж байна цахим зөвлөмж 13 багийн 221 эмч, бага дунд ангийн сурагчдын дунд “Миний төсөөллөөр эмч хүн” гар зургийн уралдаанд 600 гаруй хүүхэд оролцон, шилдгүүдээ шалгарууллаа.

Төв аймаг Эрүүл мэндийн цахим хуудсаараа дамжуулан “Эмч тандаа баярлалаа” талархлын аян өрнүүлж байна. 2023 онд АНЭ, 26 СЭМТ-д хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгалын бодис, урвалж оношлуурын тендер зарлагдсан.

Аргалант, Баянцагаан, Баян, Баянжаргалан, Баянхангай, Өндөрширээт, Эрдэнэсант сумын Эрүүл мэндийн төвүүд гүйцэтгэлийн санхүүжилтийн 39,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нярайн дулаацуулах ширээ авч, нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжрууллаа.

Улсын төсвийн 225,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийн байгууллагуудад спирометр аппарат, пульсоксиметр хуваарилан олголоо. 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр “Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийн хүрээнд Баянчандмань суманд “Тиймээ бид сүрьеэг устгаж чадна” уриан дор зорилтот бүлгийн 75 иргэдийг цээжний рентген шинжилгээнд хамруулан, сүрьеэ 1, сэжигтэй 3 тохиолдлыг илрүүлэн хяналтад авлаа.

Эрүүл мэндийн газар, Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар хамтран “Энэ жилдээ- Эрүүл жиндээ” нийгмийн эрүүл мэндийн урианы жилийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, 6 багийн 150 иргэн оролцож, нийгмийн эрүүл мэндийн өртөөчилсэн сургалт, сурталчилгаа зохион байгууллаа.

Сумдын ахмадын хорооны дарга нарт “Ахмад настны эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт, үйл ажиллагааны нэгтгэл” сэдвээр сургалт зохион байгуулж, аймгийн Нэгдсэн эмнэлэг, ахмадын хороотой хамтран, ХХҮГ-ын харьяа ахмадын сувилалд амарч буй 21 ахмадыг ЭХО, мэдрэлийн эмчийн үзлэг, оношилгоонд хамруулан, зөвлөгөө өгч ажиллалаа.

Эрүүл мэндийн чиглэлээр танхимын сургалт 2, цахим сургалт 2, ЭМЯ бусад дээд шатлалын байгууллагаас 3 удаа нийт 7 удаагийн сургалт зохион байгуулж, 320 эмч, мэргэжилтэн хамрууллаа. ЕБС, СӨБ-д 5 удаа сургалт зохион байгуулж 1036 хүүхэд хамрагдлаа.

Аймгийн Нэгдсэн эмнэлэг өөрийн хөрөнгөөр амбулаторын хэсгийн шатанд засвар үйлчилгээ хийж, үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүллээ.

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хүрээнд:

ЭМДЕГ-тай гэрээт 75 төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн 1,6 тэрбум төгрөгийн 17890 гүйцэтгэлд хяналт хийж, зөвлөмж хүргүүллээ.

8 сумын Эрүүл мэндийн төвийн 120 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах нь” сэдэвт ажлын байрны сургалт зохион

байгуулан, ЭМДҮЗ-ийн 01, 02, 05, 11,12-р тогтоол, ЭМДЕГ-ын даргын А/139 дугаар тушаалыг тус тус танилцуулан, чадавхжуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Соёл, урлагийн салбарын хүрээнд:

Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд “Авьяс бидний бахархал” иргэдийн урлагийн наадмыг 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгууллаа. Наадамд 25 сумын 220 гаруй иргэд, уран сайханчид оролцлоо.

Сумдын соёлын төвийн удирдлага, алба хаагчдад “Соёлын төв-Соён гэгээрлийн төв” мэргэжил арга зүйн сургалт, зөвлөгөөнийг 03 дугаар сарын 31-ний өдөр Чингис хаан, хаад язгууртны музейд зохион байгуулав.

Музей:

Монгол арт Галерейн “Уран зургийн нүүдлийн үзэсгэлэн”- тэй хамтран Хүүхэд залууст Монголын зураач, уран бүтээлчдийн бүтээлийг таниулах, тэдэнд урлагийн боловсрол олгох зорилготой “Уран зургийн боловсрол” сэдэвт сургалт-хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус сургалтад Ерөнхий боловсролын Хүмүүн ахлах сургуулийн дизайн, технонологи, зураг зүйн М.Хадбаатар багштай 12 дугаар ангийн уран зураг сонирхогч 19 сурагч оролцлоо.

“Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээ улс орон даяар 03 дугаар сарын 01-05-ны өдрийг хүртэл зохион байгууллаа. Тус өдрүүдэд 496 иргэнд музейг үнэ төлбөргүй үзүүллээ.

Угтаал-Цайдам сумын харъяат ахмад сурган хүмүүжүүлэгч Л.Бавуугийн “Онъсон бүтээл”-ийн үзэсгэлэнг дэглэж үзэгчдийн хүртээл болголоо.Үзэсгэлэн III/4-V/4-ний хооронд Төв аймгийн Музейн үзэсгэлэнгийн танхимд гарч байна

Нийтийн номын сан

Австралийн ЭСЯ-ны дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй номын сангийн үйлчилгээ, технологийн дэвшлийг ашиглан хамтран ажиллах талаар сургалт хэлэлцүүлэг явуулах бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэх зорилгын хүрээнд 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр 27 сумын соёлын төв, сургуулийн номын санч нарт мэргэжил арга зүйн сургалтыг зохион байгууллаа. Уг сургалтад 24 сумын 61 номын санчид хамрагдлаа. Мөн “Хил хязгааргүй номын сан” төсөл ЭСЯ-ны ажлын хэсэг Нийтийн номын санд номын дээжээсээ хандив өргөлөө.

2023 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Уран үгийн ертөнцөд өөрийн билэг оюуныг сорих, яруу найраг шимтэн сонирхож уран унших, зохион найруулах, авьяас чадварыг урамшуулах, үнэт зүйлсээ эрхэмлэн дээдлэх, шинээр төрж буй залуу авьяастнуудыг чадавхжуулах зорилгоор “Ухаарлаас ургасан бодол” яруу найргийн уралдааныг зохион байгууллаа. Тус уралдаанд 8 сумын 8-12 дугаар ангийн 31 сурагч оролцлоо.

Нийтийн номын сангийн гэрээр олгох танхим, Насанд хүрэгчдийн уншлагын танхим, Хүүхдийн уншлагын танхимуудаас “Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах баярын өдөр”-т зориулсан номын үзэсгэлэнгээ дэлгэлээ.Аймгийн Нийтийн номын сан нь 03 дугаар сарын байдлаар 272 байнгын уншигч, 1778 ирэгсэд, 4535 ном олгож уншуулан үйлчиллээ.

Биеийн тамир спортын чиглэлээр:

МУ-ын арслан, МУ-ын гавъяат дасгалжуулагч Л.Сосорбарамын нэрэмжит 2023 оны өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах жү-до бөхийн тэмцээнийг 2023.03.06-07-ны өдрүүдэд зохион байгуулж 10 байгууллагын 12 багийн 242 тамирчин;

Энх орончдын өдөрт зориулсан сагсан бөмбөгийн тэмцээнийг 2023.03.04-05-ны өдрүүдэд зохион байгуулж 27 сумын 49 багийн 400 гаруй тамирчин;

“Энх мэндийн харваа-2023” шагайн харвааны 18 дахь удаагийн тэмцээн 2023.03.11-ний өдөр Зуунмод суманд зохион байгуулж 14 аймаг, 6 дүүргийн 700 гаруй харваач оролцож цэц мэргэнээ сорин өрсөлдлөө.

Аймгийн аварга шалгаруулах 100 буудалт даамны өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмадын тэмцээн 2023.03.14-15-ны өдрүүдэд зохион байгуулагдан 8 сумын 10 багийн 168 тамирчин;

Эх орны төлөө хүчний байгууллагуудын дундах спортын нөхөрсөг тэмцээнийг 2023.03.09-10-ны өдрүүдэд зохион байгуулж 13 багийн 490 тамирчин;

Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан 2023 оны өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмадын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 18 сумын 25 багийн 350 гаруй тамирчид өсвөр үе 6 нас, залуучууд насад хүрэгчид, ахмадын ангилалд өрсөлдөн оюун ухаанаа сорин оролцлоо.

Баянчандмань сумын нэрэмжит өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах Волейболын тэмцээнийг 2023.03.-24-26-ны өдрүүдэд Баянчандмань суманд зохион байгуулан 15 сумын хөвгүүдийн 20 багийн 175, охидын 21 багийн 145, нийт 41 багийн 328 тамирчин оролцлоо.

Угтаал-Цайдам сумын харьяат МУ-ын гавьяат тамирчин Д.Амартүвшингийн нэрэмжит төвийн бүсийн жү-до бөхийн тэмцээнийг 2023.03.24-26-ны өдрүүдэд Зуунмод суманд зохион явуулж 5 багийн 500 гаруй тамирчид хамрагдлаа.

2023 оны хэрэглэлгүй /classic/ пауэрлифтингийн 8 дахь удаагийн удаагийн Улсын аварга шалгаруулах тэмцээн 2023.03.04-05-ны өдрүүдэд УБ хотноо зохион байгуулагдан Төв аймгийн баг тамирчид амжилттай оролцон 4 алт, 5 мөнгө, 4 хүрэл нийт 13 медаль авч багийн дүнгээр Тэргүүн байр эзэллээ.

Монголын дугуйн улирлын нээлтийн тэмцээн 2023.03.04-05-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 2 хүрэл медаль хүртлээ.

Олимпын боловсрол ба бие бялдрын хүмүүжил” сэдэвт болзолт уралдааны хүрээнд ерөнхий боловсролын 8 сургуулийн хоорондох “Олимпизм-соёл-спорт” нэртэй олимпиадад Төв аймгийн “Хүмүүн” цогцолбор сургуулийн сурагчид амжилттай оролцож 3 дугаар байр эзэллээ.

УБ хотын Арслан клубын нэрэмжит Ирээдүйн одод Таеквондагийн тэмцээн 2023.03.15-17-ны өдрүүдэд зохион байгуулагдан БТСГ-ын дэргэдэх “Эв нэгдэл клуб”-ын тамирчид амжилттай оролцож 6 медаль хүртлээ.

2023 оны Чөлөөт бөхийн Насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож тамирчин Э.Энхболд, Н.Батбилгүүн нар Хүрэл медал хүртлээ.

U15 насны чөлөөт бөхийн УАШТ 2023 оны 03 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд зохион байгуулагдаж 34 байгууллагын 715 тамирчин оролцсоноос Төв аймгийн “ТӨВ-АРЖ” багийн тамирчид 2 алт, 5 мөнгө, 8 хүрэл нийт 15 медаль хүртлээ.

U20 насны ангиллын тэмцээнд эрэгтэй 10 тамирчин өрсөлдөн 2 алт, 3 мөнгө, 3 хүрэл нийт 8 медаль багийн дүнгээр 165 оноогоор Тэргүүн байр эзэллээ.

Дорнод аймагт зохион байгуулагдсан Таеквондагийн пүмээ буюу тоот дасгалын улсын аварга шалгаруулах тэмцээнээс 12-14 насны ангилалд 1 мөнгөн медаль хүртлээ.

2023 оны 03 дугаар сард аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 5 төрлөөр, бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг 2 төрлөөр, нийтийг хамарсан уралдаан тэмцээнүүдийг зохион явуулж 3677 иргэнийг хамруулан улс, бүсийн аварга шалгаруулах 8 тэмцээнд амжилттай оролцож 10 алт, 16 мөнгө, 21 хүрэл нийт 47 медаль хүртсэн.

Боловсрол, шинжлэх ухааны чиглэлээр:

Улсын төрөлжсөн Олимпиадад 27 сумын 31 сургууль, ПК, МСҮТ-ийн 901 суралцагч, оюутан, 477 багш нийт 1378 оролцогч 13 хичээл, 54 төрлөөр оролцож улсын төрөлжсөн олимпиадын 3-ын даваанд 30 сурагч, 15 багш оролцох болзол хангалаа. Сургуулийн дүнгээр ХЦС, Баянчандмань, Заамар сумын 1-р сургуулиуд тэргүүллээ.

Боловсролын салбарын багш, албан хаагчдад зориулсан "English Reading Teachers 2023" хөтөлбөр нь 3 үе шаттайгаар явагдах бөгөөд 02 дугаар сарын 17-оос 04 дүгээр сарын 12-ыг хүртэл үргэлжилнэ. "English Reading Teachers 2023" хөтөлбөрийн 1-р үе шат 02.28-03.21-ний хооронд явагдаж дууслаа.

БШУ-ны Сайдын 2023 оны А/56 дугаар тушаалаар батлагдсан “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ” -ний журмыг үндэслэн Төв аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар нь Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төвтэй хамтран чанарын үнэлгээг 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Чанарын үнэлгээнд Төв аймаг, Баянчандмань ПТК, Эрдэнэ, Заамар МСҮТ гэсэн 4 чиглэлд 8 удирдлага, 20 мэргэжлийн багшаас эх хэл, эрх зүй, цахим ур чадвар гэсэн агуулгын хүрээнд бичгийн шалгалт авах, 8 мэргэжлийн багшийн онол болон дадлагын хичээлд ажиглалт хийх, 4 удирдлага, 8 мэргэжлийн багш, 8 ажил олгогч, 24 төгсөгч, 12 эцэг эх асран хамгаалагч, 124 суралцагчаас асуулга судалгааг цахимаар авах фокус ярилцлага танхимаар хийх ажлыг тус тус зохион байгуулсан. Мөн 124 суралцагчаас бичгийн болон ур чадварын шалгалт авсан.

2023 оны 03 дугаар 02-03-ны өдрүүдэд Хүмүүн цогцолбор сургуульд, 03 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд Батсүмбэр сумын ЕБС-ийн үйл ажиллагаанд зөвлөн тусаллаа.

2023 оны 3 сарын 23-ны өдөр манай аймагт ОХУ-ын Иркутск хотын АУИС-ийн төлөөлөгчид айлчлан ирж БШУГ-ын дарга, гадаад хэлний мэргэжилтэнтэй болон анагаахаар гадаадад суралцах сонирхолтой сурагчидтай уулзалт ярилцлага, танилцуулга хийлээ.

Албан бус насан туршийн боловсрол төв:

Е-Монгол Академитай хамтран Насан туршийн боловсролын салбарын 589 багш, удирдах ажилтны цахим ур чадварыг сайжруулах бүсчилсэн цахим сургалтад Насан туршийн

боловсролын төвийн удирдах ажилтан, менежер, арга зүйч, сумын нэгжийн 27 багш хамрагдлаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:

МЦХ-ТӨХК-ийн Төв аймгийн салбар, Дэлхийн Зөн ОУБ-ын хөгжлийн хөтөлбөртэй хамтран Зуунмод сумын ХЦБага сургууль, 5 дугаар сургуулиудад “Итгэлтэй утас”-ыг байршуулж, 2648 хүүхдийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлж, аюулгүй байдлыг хангах, гэр бүлтэйгээ үнэ төлбөргүй холбогдох боломжийг бүрдүүлж байна.

“Хүүхдийн тусламжийн-108” утсанд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 16 дуудлага мэдээлэл бүртгэгдэж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Монгол цэргийн өдрийг угтан “Z үе ба хөвгүүд” арга хэмжээг ДЗОУБ-ын хөгжлийн хөтөлбөр, МГБССН-ийн Төв аймаг дахь салбар, Аймгийн Хүүхдийн зөвлөлтэй хамтран Зуунмод суманд зохион байгуулан тус сумын ерөнхий боловсролын 4 сургууль, ПТК, ахлах, дунд ангийн 150 гаруй хөвгүүдийг оролцуулж, “Үерхэл нөхөрлөл ба хайр дурлал”, “Хорт зуршил бидний сонголт биш”, “Хөвгүүдийн бэлгийн ариун цэвэр, эрүүл мэнд”, “Цэргийн алба ба амьдралын сургууль”, “Миний биеийн аюулгүйн дүрэм” зэрэг сэдвийн хүрээнд мэдээллийг хүргэсэн.

Борнуур сумын хамтарсан баг, Эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж, 3 төрлийн сургалт мэдээлэл, 2 дуудлага мэдээлэл, кейс шийдвэрлэлтэд арга зүйн дэмжлэг үзүүлж, бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж ажиллалаа. Мөн Баянцогт сумын нутаг дэвсгэрт зохион байгуулагдсан “Дүнжингарав-Топ хурд 2023” хаврын уралдааныг Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд таслан зогсоож хурдан морь уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангаж, эрсдлээс урьдчилан сэргийллээ.

Аймгийн ГХУСАЗЗ, “Галт шувуу холбоо” ТББ-ын гүйцэтгэх захиралтай хамтран Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх, хамтарсан багийн гишүүдэд арга зүйн дэмжлэг үзүүлж кейс менежмент хийх үе шат, кейс файл бүрдүүлэх мэдлэг, ур чадварыг олгох бүсчилсэн сургалтыг Алтанбулаг суманд зохион байгууллаа. Тус сургалтад Алтанбулаг, Баян-Өнжүүл, Баянцагаан, Бүрэн, Дэлгэрхаан сумын 43 албан хаагч хамрагдаж, мэдлэг ур чадвараа дээшлүүллээ.

ДОЛОО: ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД:

Төв аймгийн Засаг даргын 2023 оны А/134 тоот захирамжаар “Монгол цэргийн өдөр” орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны яруу алдарт 102 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг аймаг болон сумдын иргэд, залуучуудад сурталчлах ажлын хэсэг байгуулан, тусгай төлөвлөгөө гарган төрийн цэргийн болон хуулийн байгууллагуудын харилцан ажиллагааг бэхжүүлэх, цэргийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор спортын тэмцээн уралдаан зохион байгуулан явуулж, иргэд олон түмэнд төрийн цэргийн байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлах зэрэг арга хэмжээг орон нутагтаа зохион явууллаа.

Монгол цэргийн өдөр, Орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 102 жилийн ойг тохиолдуулан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулж байгаа “Эх орны төлөө-2023” тэмцээн Зуунмод хотноо 3 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд аймгийн Бие тамир, спортын газарт зохион байгуулагдлаа. Тус тэмцээнд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын 13 багийн 500 орчим тамирчид волейбол, 3х3 сагсан бөмбөг, теннис, дартс, даамны төрлүүдээр хурд хүчээ үзлээ.

Аймгийн Засаг даргын нэрэмжит марш тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн 2023 оны 03 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд ЗХ-ний 016 дугаар нэгтгэлийн байнгын байрлалд зохион байгуулагдаж, мэргэжлийн ур чадвар, авхаалж самбаа, тэсвэр хатуужилыг сорьсон тус тэмцээнд 7 байгууллагын 100 гаруй албан хаагчид оролцсон нь ур чадвар жилээс жил нэмэгдсэн байна. 2023 оны тэмцээний удирдамжид цэрэг, эх орон, тусгаар тогтнол, газар нутаг, түүх соёл, ёс заншлын агуулга бүхий “Урлаг” зохиомжит тоглолтыг оруулж өгсөн нь онцлог байв.

“Монгол цэргийн өдөр”, орчин цагийн Зэвсэгт хүчний 102 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагчийн нэрэмжит буудлагын тэмцээнийг Төв аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлагуудын дунд зохион явууллаа.

Аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб, МЦНХ-ны Төв аймаг дахь салбар хороотой хамтран Зэвсэгт хүчний 102 жилийн ой, “Монгол цэргийн өдөр”-ийг тохиолдуулан чөлөөнд байгаа ахмад дайчидтай “АЛБА БҮХЭН САЙХАН” телевизийн нэвтрүүлэг зохион байгуулж,

нэвтрүүлэгт чөлөөнд байгаа Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн бэлтгэл хошууч С.Баттөр, Онцгой байдлын газрын бэлтгэл ахмад Ж.Батсайхан, аймгийн Цагдаагийн газрын бэлтгэл хурандаа Г.Энхбаатар нар уригдан оролцлоо. Нэвтрүүлгийг Цэргийн баярын өдөр буюу 3 дугаар сарын 18-ны өдөр сошиал болон мэдээллийн суваг, телевизээр олон нийтэд хүргэсэн. Иргэд залуучуудад, өсвөр үеийнхэнд Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлтэй хамтран хугацаат алба хаагчдын үйл ажиллагааг сурталчилсан “Хүүгийн бодол” контентийг Төв телевизтэй хамтран хийж олон нийтэд хүргэлээ.

2023 оны 03 дугаар сарын 17-ны өдөр Төв аймгийн удирдлагууд, Хуурай замын цэргийн командлалын удирдлага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын удирдлага, бие бүрэлдэхүүн, Зуунмод хотын удирдлагууд, төрийн албан хаагчид, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын төлөөлөл Монгол улсын баатар Дуламдоржийн Самдан, Монгол Улсын баатар, хурандаа генерал Бутачын Цогийн хөшөөнд тус тус цэцэг өргөж, хүндэтгэл үзүүлсэн. Мөн Төрийн цэргийн болон хуулийн байгууллагын албан хаагчид их зохиолч Д.Нацагдоржийн нэрэмжит "Мөнх-Алдарын талбай"-д баярын ёслолын жагсаал зохион байгууллаа.

“Зуунмод” цэргийн хүрээний анги, байгууллагын нэгдсэн туяа тооны үеэр, Зэвсэгт хүчин, анги байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан зурагт самбар, зэвсэг, техникийн үзэсгэлэн гарч, марш тактикийн тэмцээний аварга, тасгуудын жагсаалын болон гардан тулаан үзүүлэх тоглолтыг иргэдэд сонирхууллаа. Энэ үеэр Төв аймгийн Засаг даргын нэрэмжит Марш тактик, тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээний шагналыг гардууллаа.

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР